



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 11 өдөр

Дугаар 8/472

Мөрөн сум

Теле камерын төв байгуулж,
эзэмшил шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 74 дүгээр зүйлийн 74.1, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.4, 28 дугаар зүйлийн 28.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн цагдаагийн газрын теле хяналтын камерын системийг Төрийн банкны Мөрөн сумын 8-р багт байрлах/“Хөвсгөл АЗЗА” ОНӨК-тай хамтран эзэмшдэг/ байранд шилжүүлэн оруулж “Телекамерын хяналтын дэд төв”-ийг байгуулсугай.

2.Цагдаагийн газрын телекамерын хяналтын системийг аймгийн Засаг даргын тамгын газрын эзэмшилд шилжүүлж, цагдаагийн газрыг эзэмшигч байгууллага байхаар шийдвэрлэсүгэй.

3.Телекамерын системийг нүүлгэн шилжүүлж, “Телекамерын хяналтын дэд төв”-ийг байгуулах ажлын хэсгийг аймгийн Хууль, эрх зүйн хэлтэс, Төрийн цахим үйлчилгээний хэлтэс, Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлогын хэлтэс, Цагдаагийн газар, Онцгой байдлын газар, Эрүүл мэндийн газар, “Мэдээлэл, холбооны сүлжээ” ТӨК, “Хөвсгөл эрчим хүч” ХХК-ийг оролцуулан байгуулсугай.

4.“Телекамерын хяналтын дэд төв”-ийг байгуулахад шаардагдах зардлыг тооцон гаргаж, 2025 оны аймгийн төсөвт тусгах, камерын систем байрлуулах байрны түрээсийн гэрээг Төрийн банкттай байгуулахыг аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс/Г.Базар/, Цагдаагийн газар /дэд хурандаа Д.Мөнхжаргал/-т даалгасугай.

5.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /М.Хуягбаатар/-т үүрэг болгосугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ